



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот

Тэмцээнд оролцуулах тухай

Нийслэлийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр, Засаг даргын А/600 дугаар захирамжийг хэрэгжүүлэх, Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. ОХУ-ын Новосибирск хотноо 2013 оны 06 дугаар сарын 10-наас 07 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохиогдох “Спорт – Урлаг – Оюун ухаан” сэдэвт Олон улсын хүүхдийн спортын их наадамд оролцох нийт 72 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчид (52 хүүхэд, 20 багш дасгалжуулагч)-ыг спортын 9 төрлөөр оролцуулсугай.

2. Их наадамд оролцох төлөөлөгчдийн зардлыг хавсралтаар баталсугай.

3. Их наадамд оролцоход шаардагдах нийт 3.129.980 /гурван сая нэг зуун хорин есөн мянга есөн зуун наяд/ төгрөгийг Биеийн тамир, спортын газрын орон нутгийн төсвөөс гаргахыг нягтлан бодогч Ж.Цэдэнсодномд зөвшөөрсүгэй.

4. Их наадамд оролцох бэлтгэл ажлыг хангаж, баг тамирчид, мэргэжилтнүүдийг оролцуулахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2013 оны дундаар сарын 13-ны өдрийн
А/37 дугаар тушаалын хавсралт



ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ИХ НААДАМД ОРОЛЦОХ
МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Нийт дүн
1.	Галт тэрэгний зардал: Улаанбаатар – Новосибирск – Улаанбаатар: $256.700 \text{ ₮} \times 7 \text{ хүн} = 1.796.900 \text{ /төг/}$	1.796.900 төг
2.	Визний зардал: $30 \$ \times 1433 \text{ /төг/} \times 7 \text{ /хүн/} = 300.930 \text{ /төг/}$	300.930 төг
3.	Томилолтын мөнгө: $147.450 \text{ ₮} \times 7 \text{ хүн} = 1.032.150 \text{ /төг/}$	1.032.150 төг
ДҮН:		3.129.980 төг